БАТЛАВ

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА Н.НАРАНБААТАР

*2026 оны .... дугаар....сарын .....*

9025101255 СТС6091 9077456

# НИЙСЛЭЛИЙН ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗРЫН 2026-2029 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

НИЙСЛЭЛИЙН ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗРЫН

ДАРГА Н.БАТСАЙХАН

9024031101

9077006 ▲ ХН[illegible]

Улаанбаатар хот

2026 он

## АМАРЖИХ ГАЗРЫН 2026-2029 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ, АГУУЛГА


**БҮЛЭГ 1**. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**БҮЛЭГ 2.** МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

**БҮЛЭГ 3.** АЛСЫН ХАРАА

**БҮЛЭГ 4.** ЭРХЭМ ЗОРИЛГО

**БҮЛЭГ 5.** ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

**БҮЛЭГ 6.** СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

**БҮЛЭГ 7.** СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН ЗУРАГЛАЛ

**БҮЛЭГ 8.** СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН, СТАРТЕГИ

**БҮЛЭГ 9**. ХАВСРАЛТ. АМАРЖИХ ГАЗРЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

# НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

## 1.1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Амаржих газар нь үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Төрийн албаны тухай хууль, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон нийслэлийн Засаг даргын шийдвэр, холбогдох бусад хууль тогтоомж, стандарт, журмыг хэрэгжүүлэн харьяа эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр хангах, нийслэлийн хэмжээнд эх барих, эмэгтэйчүүд, нярай, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээ үзүүлэх, эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулах, эмнэлзүй, эрдэм шинжилгээ судалгааны ажил эрхлэх, эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил, арга зүй, удирдлагаар хангах чиг үүрэг бүхий эмнэлэг юм. Мөн иргэдэд тэгш хүртээмжтэй, чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжил, ур чадвараа дээшлүүлэх боломж нөхцөлөөр хангах, үйл ажиллагаагаа иргэдэд нээлттэй, ил тод, иргэдийн оролцоог хангасан байх зарчмыг баримталдаг.

Амаржих газар нь Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны А/19 дүгээр тушаалаар батлагдсан “Амаржих газрын дүрэм, бүтэц орон тоог батлах тухай” чиглэлийн дагуу 2 зөвлөл, 4 орлогч дарга, 10 тасаг, 10 алба, 1 төвийн бүтэцтэй ажиллаж байна. Үүнд:

**Баг, зөвлөл:**

1. Удирдлагын баг
2. Удирдлагын зөвлөл
3. Эрдмийн зөвлөл

**Орлогч дарга**

1. Төлөвлөлт үйл ажиллагаа эрхэлсэн орлогч дарга
2. Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга
3. Сувилахуй эрхэлсэн орлогч дарга
4. Сургалт, эрдэм шинжилгээ хамтын ажиллагаа эрхэлсэн орлогч дарга

**Алба:**

1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба
2. Санхүүгийн алба
3. Захиргаа хүний нөөцийн хөгжлийн алба
4. Сувилахуйн алба
5. Халдвараас сэргийлэх, хяналтын алба

6. Эмзүйн алба
7. Сургалт, эрдэм шинжилгээ, хамтын ажиллагааны алба
8. Эрүүл мэндийн даатгал, статистик, мэдээлэл, технологийн алба
9. Инженер техникийн алба
10. Хангамж үйлчилгээ, аж, ахуйн алба
11. Нийгмийн эрүүл мэндийн дэмжих төв

**Тасаг:**

1. Төрөх, төрсний дараах тасаг
2. Эрсдэлтэй жирэмсний тусламжийн тасаг
3. Хүлээн авах, яаралтай тусламжийн тасаг
4. Дутуу тээлтийн тасаг
5. Эмэгтэйчүүдийн эмгэг судлалын тасаг
6. Нярайн тасаг
7. Амбулаторийн тасаг
8. Мэс засал, мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний тасаг
9. Лабораторийн тасаг
10. Сэргээн засах, уламжлалт эмчилгээний тасаг

Амаржих газар нь Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/608 дугаар тушаал, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2024 оны А/19 дүгээр тушаалд заасны дагуу Амаржих газрын стратеги төлөвлөгөө боловсруулах шаардлагатай болсон.

Хүснэгт 1.

**Амаржих газрын бүтцийн нэгж, хүний нөөц**

| № | Бүтцийн нэгжүүд | Хүний нөөцийн тоо | Одоо байгаа |
|---|---|---|---|
| Удирдлага | | | |
| 1 | Удирдлагын баг | 9 | 9 |
| 2 | Удирдлагын зөвлөл | 27 | 27 |
| 3 | Эрдмийн зөвлөл | 14 | 14 |
| 4 | Төлөвлөлт, үйл ажиллагаа эрхэлсэн орлогч дарга | 1 | 0 |
| 5 | Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга | 1 | 1 |
| 6 | Сувилахуй эрхэлсэн орлогч дарга | 1 | 1 |
| 7 | Дотоод хяналтын ажилтан | 1 | 1 |

| | | | |
|---|---|---|---|
| Алба | | | |
| 1 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба | 5 | 3 |
| 2 | Санхүүгийн алба | 10 | 6 |
| 3 | Захиргаа хүний нөөцийн хөгжлийн алба | 13 | 7 |
| 4 | Сургалт, эрдэм шинжилгээ, хамтын ажиллагааны алба | 3 | 2 |
| 5 | Эрүүл мэндийн даатгал, статистик, мэдээлэл, технологийн алба | 9 | 6 |
| 6 | Нийгмийн эрүүл мэндийн дэмжих төв | 16 | 13 |
| 7 | Хангамж үйлчилгээ, аж, ахуйн алба | 26 | 14 |
| 8 | Инженер техникийн алба | 8 | 7 |
| 9 | Халдвараас сэргийлэх, хяналтын алба | 23 | 25 |
| 10 | Эмзүйн алба | 11 | 5 |
| 11 | Сувилахуйн алба | 4 | |
| Тасаг, нэгж | | | |
| 1 | Төрөх, төрсний дараах тасаг | 40 | 41 |
| 2 | Эрсдэлтэй жирэмсний тусламжийн тасаг | 26 | 27 |
| 3 | Хүлээн авах, яаралтай тусламжийн тасаг | 18 | 17 |
| 4 | Дутуу тээлтийн тасаг | 20 | 19 |
| 5 | Эмэгтэйчүүдийн эмгэг судлалын тасаг | 26 | 27 |
| 6 | Нярайн тасаг | 48 | 46 |
| 7 | Амбулаторийн тасаг | 27 | 22 |
| 8 | Мэс засал, мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний тасаг | 40 | 37 |
| 9 | Лабораторийн тасаг | 13 | 12 |
| 10 | Сэргээн засах, уламжлалт эмчилгээний тасаг | 9 | 9 |
| Нийт ажилтан | | 399 | 347 |

## 1.2. ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичиг "Алсын хараа 2050", Нийслэлийн Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/1480 дугаар захирамжаар батлагдсан "Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны "Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө", Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/219 дүгээр тушаал "Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээний төлөвлөгөөг тус тус үндэслэж боловсруулсан.

Стратеги төлөвлөгөөг Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам"-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төрийн байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулах ерөнхий удирдамж аргачлалын дагуу боловсруулсан.

Нийслэлийн хэмжээнд эх, нярайн тусламж үзүүлэхийн зэрэгцээ төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ бүхий эмнэлэг болж хөгжих нь Амаржих газрын цаашдийн зорилго болж байна. Сүүлийн жилүүдэд эх, нярайн тусламж үйлчилгээний хэрэгцээ өсөн нэмэгдэж, өндөр эрсдэлтэй жирэмслэлт, төрөлтийн эзлэх хувь нэмэгдэж байна. Гуравдагч шатлалын эмнэлгүүдэд ачаалал хэт төвлөрсөн бөгөөд Өргөө амаржих газар нь бодит үйл ажиллагааны хувьд өндөр эрсдэлтэй тусламжийг тогтмол үзүүлж эх, нярайн хүндрэл эндэгдлийг бууруулах, пренатал илрүүлэг, нярайн илрүүлэг шинжилгээг хөгжүүлэх, нярайн тусламж үйлчилгээнд орчин үеийн шинэ технологийг нэвтрүүлэх, эмнэлгийн мэргэшсэн тусламжийн тасралтгүй байдал, чанарын стандартын шаардлага ханган ажиллаж байна.

## 1.3. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ОРЧИН

- ✓ Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хууль
- ✓ Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль
- ✓ Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- ✓ Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль
- ✓ Эрүүл ахуйн тухай хууль
- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Төрийн албаны тухай хууль
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль
- ✓ Шилэн дансны тухай хууль
- ✓ Гамшгаас хамгаалах тухай хууль

## ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан "Чиг үүрэг дахин хувиарлах аргачлал"-ын дагуу салбарын чиг үүргийн мандатыг 2023 онд батласан.

Тус амаржих газар нь нийслэлийн хэмжээнд эх барих, эмэгтэйчүүд, нярай, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээ үзүүлэх, эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулах, эмнэлзүй, эрдэм шинжилгээ, судлагааны ажил эрхлэх, эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил, арга зүй, удирдлагаар хангах чиг үүрэг бүхий эмнэлэг юм.

**Алхам 1. Нийслэлийн Өргөө амаржих газрын үйл ажиллагаанд хамаарах чиг үүргийг тодорхойлох**

Бүдүүвч зураг №1



Чиг үүрэг дахин хуваарлах аргачлалын дагуу хийгдсэн дүн шинжилгээг үндэслэн Амаржих газрын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн орчны хүрээнд мандатын шинжилгээг дараах байдлаар хийв.

Хүснэгт 2.

Мандатын шинжилгээний хүснэгт

| | | |
|---|---|---|
| Амаржих газрын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо | | 231 |
| Үүнээс: | Салбарын хэмжээнд шууд хамаарах хуулийн тоо | 12 |
| | Нийтлэг мөрдөгдөх хуулийн тоо | 219 |
| Ерөнхий чиг үүрэг-1: Хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах | | |
| Үндсэн чиг үүрэг | Дэд чиг үүрэг | Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид |
| ҮЧҮ-1: Эх барихын тусламж, үйлчилгээ | Жирэмслэлт, төрөлт, төрсний дараах үед үзүүлэх тусламж, үйлчилгээ | Нийслэлийн Эрүүл мэндийн газар, ЭМХТ, НЭМҮТ, ЭХЭМҮТ болон Үндэсний төв эмнэлэгүүд, төр болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд, мэргэжлийн нийгэмлэг, холбоод, төрийн бус байгууллагууд, ААН, иргэд, үйчлүүлэгч |
| | Ураг, нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээ | |
| | Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээ | |
| | Эмэгтэйчүүд, нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх | |
| ҮЧҮ-2: Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ | Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үйл ажиллагаа | Нийслэлийн Эрүүл мэндийн газар, ЭМХТ, НЭМҮТ, боловсролын байгууллагууд, олон нийтийн мэдээллийн суваг, төрийн бус |
| | Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлийг тандах үйл ажиллагаа | |
| | Эрүүл мэндийг тандах үйл | |

| | | |
|---|---|---|
| | ажиллагаа<br>Эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл, сургалт, сурталчилгаа | байгууллагууд, ААН, иргэд, үйчлүүлэгч |
| ҮЧҮ-3: Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ | Эмчлэх тусламж, үйлчилгээ<br>Сэргээн засах тусламж, үйлчилгээ<br>Эх, нярай, эмэгтэйчүүдийн сувилгаа, асаргааны тусламж, үйлчилгээ<br>Яаралтай тусламж, үйлчилгээ | Нийслэлийн Эрүүл мэндийн газар, ЭМХТ, НЭМҮТ, Үндэсний төв эмнэлэгүүд, төр болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд, мэргэжлийн нийгэмлэг, холбоод, төрийн бус байгууллагууд, ААН, иргэд, үйчлүүлэгч |
| ҮЧҮ-4: Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх | Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт зохион байгуулах<br>Анагаах ухааны дэвшилтэт технологи, ололт амжилт, иновацийг эмчилгээ үйлчилгээнд нэвтрүүлэн үр дүнг тооцож санал боловсруулан ажиллах<br>Сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх | ЭМХТ, мэргэжлийн нийгэмлэг, холбоод |

**Алхам 2. Холбогдогч талуудыг тодорхойлох**

Холбогдогч талуудыг тодорхойлохдоо Нийслэлийн Өргөө амаржих газраас бусад байгууллагуудтай харилцах эрх хэмжээг үндэслэсэн болно.

Үүнийг ерөнхий байдлаар авч үзвэл Нийслэлийн Өргөө амаржих газар нь:

1. Дээшээ чиглэлд дээд шатны байгууллага, албан тушаалтнаас гаргасан бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, ажлын үр дүнгээ тайлагнах, үйл ажиллагаагаа уялдуулан зохион байгуулах, эх, нярай, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр санал боловсруулж хүргүүлэх, дэмжлэг авах;

2. Хэвтээ чиглэлд үйл ажиллагаа уялдуулан зохион байгуулах, хамтран ажиллах, саналаа уламжлах, мэргэжил арга зүйн дэмжлэг авах;

Амаржих газрын үйл ажиллагаанд холбогдогч талуудыг дараах бүдүүвч зурагт үзүүлэв.

Бүдүүвч зураг №1




Эдгээр холбогдогч талуудын оролцоог хангах, харилцан мэдээлэх, зөвлөх, санал хүргүүлэх, шийдвэр гаргах гэсэн ерөнхий ангилалын хүрээнд тодорхойлсон. Үүнийг дараах хүснэгтээр харуулж байна.

Хүснэгт №3. Холбогдогч талуудын оролцоо

| Холбогдогч талууд | Оролцоо | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Мэдээлэх | Зөвлөх | Санал өгөх | Хамтран ажиллах | Шийдвэр гаргах | Бусад |
| Нийслэлийн эрүүл мэндийн газар | + | | + | | + | |
| Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар | | | + | + | | |
| Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар | | | + | | | |
| Эрүүл мэндийн хөгжлийн төв | | | + | + | | |
| ЭМЯ-ны харьяа ЭМБ | + | + | + | + | | |
| НЭМГ-ын харьяа ЭМБ | + | + | + | + | | |
| Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ, ОУБ | | + | + | + | | |
| Сургалт судалгааны байгууллага | + | | + | + | | |
| Хэвлэл мэдээллийн байгууллага | | | | | | |
| Нийслэлийн боловсролын байгууллага | | + | + | + | | |
| Иргэн, аж ахуйн нэгж | | + | | | | |

### Алхам 3. Чиг үүргийн хэрэгжилтийг тодорхойлох

Хүснэгт №4 Нийслэлийн Өргөө амаржих газрын чиг үүргийн хэрэгжилт, хувиар

| № | Чиг үүрэг | | Чиг үүргийн хэрэгжилтийн үнэлгээ | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2021 он | 2022 он | 2023 он | 2024 он | 2025 он |
| 1 | НӨАГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт | | 87.8% | 72.8% | 82.6% | 93.2% | 98.6% |
| Тусламж үйлчилгээний үндсэн үзүүлэлт | | | 2021 он | 2022 он | 2023 он | 2024 он | 2025 он |
| 1 | Төрсөн эх | | 9554 | 7943 | 7030 | 5838 | 5434 |
| 2 | Амьд төрөлт | | 9611 | 8007 | 7058 | 5864 | 5447 |
| 3 | Амьгүй төрөлт 1000 амьд төрөлтөд | Улсын дундаж | 5.5 | 5.3 | 5.3 | 5.0 | 4.6 |
| | | НӨАГ-ын түвшин | 5.0 | 3.4 | 4.7 | 4.7 | 5.3 |
| 4 | Эхийн эндэгдэл 100.000 амьд төрөлтөд | Улсын дундаж | 94.9 | 35.1 | 26.4 | 22.5 | 31.4 |
| | | НӨАГ-ын түвшин | 10.4 | 0 | 28.4 | 17.1 | 18.4 |
| 5 | Нялхасын эндэгдэл 1000 амьд төрөлтөд | Улсын дундаж | 11.6 | 12.4 | 13.1 | 12.2 | 13.6 |
| | | НӨАГ-ын түвшин | 1.9 | 2.4 | 5.7 | 3.4 | 6.8 |
| 6 | Нярайн эндэгдэл 1000 амьд төрөлтөд | Улсын дундаж | 8.1 | 8.5 | 7.7 | 7.5 | 8.5 |
| | | НӨАГ-ын түвшин | 1.9 | 2.4 | 5.7 | 3.4 | 6.8 |
| 7 | Пренатал эндэгдэл 1000 амьд төрөлтөд | Улсын дундаж | 11.8 | 10.8 | 10.4 | 9.8 | 10.5 |
| | | НӨАГ-ын түвшин | 7.0 | 5.2 | 9.1 | 7.1 | 9.9 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | Ор хоног | Орны хөдөлгөөн | 92964 | 115049 | 109194 | 89758 | 103873 |
| | | Фонд ашиглалт | 77.6 | 86.8 | 82.4 | 69.5 | 72.0 |
| 9 | Дундаж ор хоног | | 4.4 | 5.3 | 5.2 | 5.2 | 5.2 |
| 10 | Орны эргэлт | | 57.9 | 59.4 | 58.2 | 49.1 | 50.9 |
| 11 | Төрөлтийн хүндрэл, хувиар | | 24.6 | 28.9 | 11.5 | 24.7 | 37.3 |
| 12 | Кесар мэс засал, хувиар | Улсын дундаж | 27.6% | 27.1% | 27.9% | 28.2% | 28.9% |
| | | НӨАГ | 35.1% | 33.4% | 36.6% | 35.1% | 37.8% |

Дүн шинжилгээ хийхдээ Амаржих газрын чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон.

**Эрүүл мэндийн статистик үзүүлэлтүүд:**

Нийслэлийн хүн ам зүйн өөрчлөлтүүд

- Нийслэлийн хүн амын өсөлтийн 5 жилийн үзүүлэлт



➢ Монгол Улсын дундаж төрөлт (нийт төрөлтөд эзэлэх хувиар):




➢ Нийслэлийн нийт төрөлт (1989-2023 он):



- **Амаржих газрын төрөлт (2021-2025 он):**




- Эх, нярайн эндэгдлийн үзүүлэлт (Улсын дундажтай харьцуулах)



➢ Нярайн эндэгдэл, Улсын дундажтай харьцуулсан:




➢ Пренатал эндэгдэл, Улсын дундажтай харьцуулсан:



## ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Эх барих, эмэгтэйчүүд, нярайн тусламж үйлчилгээний салбарт иновацийн манлайлагч, хөгжилд тэргүүлэгч эмнэлэг байна.

## ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Өндөр эрсдэлтэй жирэмслэлт, төрөлт, нярай, эмэгтэйчүүдийн тусламжийг нотолгоонд суурилсан, аюулгүй, чанартай, тасралтгүй үзүүлэх.

## ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

5.1. **SWOT шинжилгээ**

| Дотоод орчин | |
|---|---|
| Давуу тал | Сул тал |
| Улаанбаатар хотын эх барих, нярайн тусламжийн хамгийн өндөр ачаалалтай, туршлагатай байгууллага<br>Эх барих, эмэгтэйчүүд, нярайн тусламжийн мэргэшсэн эмч, сувилагчийн суурь баг бүрдсэн<br>Өндөр эрсдэлтэй жирэмслэлтийн бодит туршлага, кейсийн их сан<br>ЭМЯ, нийслэлийн эрүүл мэндийн сүлжээнд лавлагааны чухал зангилаа<br>Олон нийтийн итгэл, танигдсан нэр хүнд | Мэргэшсэн тусламжийн эрх зүйн статус тодорхой бус (III шатлалтай дүйцэх эсэх)<br>Нярайн эрчимт эмчилгээ болон дэд мэргэшлийн тусламж орон тоо, тоног төхөөрөмжийн хязгаарлалттай<br>Ачааллаас шалтгаалсан ажлын ядаргаа, хүний нөөцийн тогтворгүй байдал<br>Чанар, аюулгүй байдлын нэгдсэн дотоод аудит, эрсдэлийн тогтолцоо сул<br>Судалгаа, сургалтын тогтолцоо тогтворжоогүй |
| Гадаад орчин | |

| Боломж | Эрсдэл |
|---|---|
| Эх, нярайн эндэгдлийг бууруулах үндэсний бодлого, зорилт<br>ЭМД-ын санхүүжилтийн шинэчлэл, мэргэшсэн тусламжийн тариф нэвтрэх боломж<br>Гуравдагч шатлалын төвүүдийн ачааллыг хуваалцах бодлогын хэрэгцээ<br>Олон улсын байгууллага, төсөл (WHO, UNICEF)-тэй хамтрах боломж<br>Сургалтын эмнэлэг, үндэсний лавлагаа төв болох потенциал | Хүний нөөц гуравдагч шатлалын болон хувийн эмнэлгүүд рүү шилжих<br>Санхүүжилт хангалтгүйгээс тоног төхөөрөмжийн шинэчлэл удаашрах<br>Эрх зүйн тодорхой бус байдлаас стратеги хэрэгжихгүй саатах<br>Ачаалал нэмэгдэхийн хэрээр чанар, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх |

5.2. Gap analysis (Одоогийн байдал ба шаардлагатай түвшний зөрүү)

5.2.1 Эрх зүй, бодлогын gap

| Шаардлагатай түвшин | Одоогийн байдал | Зөрүү |
|---|---|---|
| Мэргэшсэн тусламжийн албан ёсны статус | Ерөнхий амаржих газрын статустай | Эрх зүйн шинэчлэл шаардлагатай |

5.2.2 Үйлчилгээний чадавхийн gap

| Чиглэл | Шаардлагатай | Одоогийн | Зөрүү |
|---|---|---|---|
| Өндөр эрсдэлтэй жирэмслэлт | III түвшний тусламж | Хэсэгчлэн | Баг, протокол дутмаг |
| Нярайн эрчимт эмчилгээний тасаг | Бүрэн хүчин чадал | Хязгаарлагдмал | Ор, тоног төхөөрөмж |
| Ургийн оношилгоо | III түвшин | II түвшин | Мэргэжил, тоног |

5.2.3 Хүний нөөцийн gap

| Шаардлага | Одоогийн | Зөрүү |
|---|---|---|
| Дэд мэргэшсэн эмч | Хязгаарлагдмал | Сургалт, орон тоо |
| Нярайн эрчимт эмчилгээний тасгийн сувилагч | Дутмаг | Тусгай сургалт |

5.2.4 Чанар, аюулгүй байдлын gap

| Шаардлагатай тогтолцоо | Одоогийн | Зөрүү |
|---|---|---|
| Клиник аудит | Тогтмол бус | Системчлэл |
| Эрсдэлийн менежмент | Тархмал | Нэгдсэн тогтолцоо |

5.2.5 Санхүүжилт, удирдлагын gap

| Шаардлага | Одоогийн | Зөрүү |
|---|---|---|
| Мэргэшсэн тариф | Байхгүй | Бодлогын шийдвэр |
| Гүйцэтгэлд суурилсан удирдлага | Хэсэгчилсэн | KPI систем |

5.3. Стратегийн дүгнэлт: SWOT ба Gap шинжилгээ нь Өргөө амаржих газрыг мэргэшсэн тусламжийн эмнэлэг болгоход чадавхын суурь сайн, харин эрх зүй, нярайн эрчимт эмчилгээний тасаг, хүний нөөц, чанарын тогтолцоо дээр төвлөрсөн шинэчлэл шаардлагатайг харуулж байна.

## ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Стратегийн төлөвлөгөө нийт **7** зорилт, **19** зорилт, **65** арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

**СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 1.**

**ЭХ, НЯРАЙ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАЖ, СЭРГИЙЛЖ БОЛОХ ЭНДЭГДЛИЙГ БУУРУУЛЖ АЖИЛЛАХ**

*Зорилт 1.*

Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулж, сэргийлж болох эндэгдлийг бууруулах ажлыг зохион байгуулах

*Зорилт 2.*

Нярайн тусламж үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулж, сэргийлж болох эндэгдлийг бууруулах ажлыг зохион байгуулах

*Зорилт 3.*

Бичил биетний тэсвэржилтийн эсрэг үйд ажиллагааг хэрэгжүүлж, эмийн аюулгүй байдлыг хангаж ажиллах

*Зорилт 4.*

Яаралтай тусламж, амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээний ур чадварыг сайжруулж, багаар тусламж үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллах

*Зорилт 5.*

Нөхөн үржихүйн эмэгтэйчүүдэд чиглэсэн гэр бүл төлөвлөлтийн боловсрол олгох, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж ажиллах

*Зорилт 6.*

Халдварын сэргийлэлт хяналтын тогтолцоог бүрдүүлж, эмнэлгээс шалтгаалах халдварын тандалт судалгааг тогтмолжуулж, сэргийлэх үйл ажиллагааг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах

*Зорилт 7.*

Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдлийн удирдлагы тогтолцоог бүрдүүлэх

**СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 2: ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭР ТӨРӨЛ, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ.**

Зорилт-1.

Үйлчлүүлэгчидэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх

Зорилт-2.

Амбулатори, хүлээн авах, хэвтүүлэн эмчлэх тасгийн зохион байгуулалтыг үйл ажиллагаа,

үйлчилгээний

ачаалал, эрэлт хэрэгцээ, үйлчлүүлэгчийн урсгал, хөдөлгөөнтэй уялдуулан зохион байгуулах

Зорилт-3.

Эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг өргөжүүлэх

**СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 3: СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫГ САЙЖРУУЛЖ, ЖИГД ХҮРТЭЭМЖТЭЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ**

Зорилт-1

Сувилахуй, эх барихуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлэх

Зорилт-2

Сувилагч, эх баригч нарын хөдөлмөрийн аюулгүй байдал хангаж, ажлын байрны эрсдэлээс хамгаалж ажиллах

**СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 4: НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАНА.**

Зорилт 1.

Халдварт бус эмгэгийн эрсдэлт хүчин зүйлийг тандах, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эмчлэх, хяналтын тогтолцоог сайжруулах

Зорилт-2.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах, илрүүлэх тандалт, хариу арга хэмжээ авч ажиллах

**СТРАТЕГИЙН ЗОРИЛГО-5: ЭМНЭЛГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЖ, ШИНЖЛЭХ УХААНЫ НОТОЛГООНД СУУРИЛСАН АНАГААХ УХААНЫ ХӨГЖҮҮЛЭН, ШИНЭ ИННОВАЦИ ХӨГЖҮҮЛНЭ.**

Зорилт-1.

Эх, нярай эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээнд нотолгоонд суурилсан анагаах ухааныг хөгжүүлж, олон улсын анагаах ухааны хөгжилтэй мөр зэрэгцэн ажиллах

Зорилт-2.

Эмнэлгийн тусламж үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлж ажиллах ажиллах

**СТРАТЕГИЙН ЗОРИЛГО-6: УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО БОЛОВСРУУЛЖ ХЭРЭГЖҮҮЛНЭ.**

Зорилт 1.

Үйлчлүүлэгч, ажилтнуудад ээлтэй орчин бүрдүүлж, тохижилтийг үе шаттай зохион байгуулан ажиллах.

Зорилт 2.

Хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, сургах, чадавхжуулах, урамшуулах арга хэмжээг хэрэгжүүлэх

**СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 7: ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН ТОГТОЛЦООНЫ ТЕХНИК ТЕХНОЛОГИЙГ САЙЖРУУЛАХ, ДЭЛХИЙН ЖИШГИЙН ЦАХИМ ЭМНЭЛГИЙГ ҮЕ ШАТТАЙ ТӨЛӨВШҮҮЛЭН ЗОХИОН БАЙГУУЛНА.**

Зорилт-1.

Мэдээллийн удирдлага, мэргэжил арга зүйгээр хангах чиглэлээр эмнэлгийн тусламж үйлчилгээг цахимжуулж, хялбаржуулах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллана.

# ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН ЗУРАГЛАЛ

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны ... дугаар сарын ... өдрийн
... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН АМАРЖИХ ГАЗРЫН БҮТЭЦ



## НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН

Амаржих газрын тусламж үйлчилгээний шалгуур үзүүлэлт 2026-2029 он

| Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| № | Үзүүлэлт | Хэмжих үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | | |
| | | | 2025 он | 2026 он | 2027 он | 2028 он | 2029 он |
| | | | | | | | |
| | | | | | | | |

## ЕС. АМАРЖИХ ГАЗРЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ 2026-2030 он

| | Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Стратеги /арга зам/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | | | | Санхүүгийн эх үүсвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2025 он | 2026 он | 2027 он | 2028 он | 2029 он | 2030 он | |
| Ерөнхий чиг үүрэг: Хүн амын эрүүл мэндийг дэмжих хамгаалах | | | | | | | | | | |
| Үндсэн чиг үүрэг: | | | | | | | | | | |
| | Зорилт -1: Хүн амын эрүүл мэндийн мэдлэг, | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсролыг дээшлүүлж НЭМ-ийн тусламж үйлчилгээг бэхжүүлэх замаар иргэдийг урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг оношилгоонд хамруулна. | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |

# БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

/ 2026-2029 он/

| Стратегийн зорилт | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Төсөв (сая.төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | | | Хариуцах нэгж | Хамтрах нэгж |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2026 он | 2027 он | 2028 он | 2029 он | | |
| **СТРАТЕГИЙН ЗОРИЛГО-1: ЭХ, НЯРАЙ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАЖ, СЭРГИЙЛЖ БОЛОХ ЭНДЭГДЛИЙГ БУУРУУЛЖ АЖИЛЛАХ** | | | | | | | | | | |
| ***Зорилт 1.*** Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулж, сэргийлж болох эндэгдлийг бууруулах ажлыг зохион байгуулах | <u>Арга хэмжээ-1</u><br>“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” 2025-2028 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. | 3.5 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 69.0 | 71.0 | 80.0 | 90.0 | 95.0 | ТТДТ<br>ЭЖТТ<br>НТ<br>ДТТ<br>АМБ | ЭМТҮЧАБА<br>Сувилахуйн алба<br>СЭШХХА |
| | <u>Арга хэмжээ-2</u><br>“Эхээс урагт дамжих гурвалсан халдвар”-ыг бууруулах эрт илрүүлэх, эмчилэх боломжийг бүрдүүлж ажиллана.<br>(HIV + тэмбүү + В гепатит) | 2.0 | Гурвалсан халдварын скринингид хамрагдсан жирэмсэн эхийн тоо | В гепатит -3148<br>Тэмбүү-3389<br>HIV-2768 | В гепатит-3500<br>Тэмбүү-3400<br>HIV-3000 | В гепатит -3600<br>Тэмбүү-3500<br>HIV-3100 | В гепатит -3500<br>Тэмбүү-3400<br>HIV-3250 | В гепатит-3700<br>Тэмбүү-3500<br>HIV-3300 | ЭЖТТ<br>АМБ | ТТДТ<br>ДТТ |
| | | | Гурвалсан халдвар зэрэг жирэмсэн эхээс шаардлагатай эмчилгээ, урьдчилан сэргийлэлт авсан эхийн тоо | В гепатит -70<br>Тэмбүү-47<br>HIV-0 | В гепатит-75<br>Тэмбүү-48<br>HIV-тохиолдолд | В гепатит -78<br>Тэмбүү-47<br>HIV-тохиолдолд | В гепатит -82<br>Тэмбүү-48<br>HIV-тохиолдолд | В гепатит-85<br>Тэмбүү-53<br>HIV-тохиолдолд | ТТДТ | ЭЖТТ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | (WHO Service coverage indicator) | | | | | | | |
| | | | ХДХВ / тэмбүү / В гепатиттай эхээс төрсөн нярайд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан нярайн тоо (АРВ, бензатин пенициллин, HBIG + вакцин) | В гепатит -64 Тэмбүү-2 HIV-0 | В гепатит-54 Тэмбүү-2 HIV-0 | В гепатит -50 Тэмбүү-2 HIV-0 | В гепатит -49 Тэмбүү-2 HIV-0 | В гепатит-45 Тэмбүү-2 HIV-0 | НТ | ТТДТ |
| | **<u>Арга хэмжээ-3</u>**<br>Сэргийлж болох эхийн эндэгдлийн бууруулна | 1.5 | 100.000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл (просантимиль) | 22.3 | 22.2 | 22.0 | 21.7 | 21.4 | ТТДТ<br>ЭЖТТ<br>ДТТ<br>АМБ<br>МЗМЭЭТ | ЭМТҮЧАБА<br>Сувилахуйн алба<br>СЭШХХА<br>ХСХА |
| | **<u>Арга хэмжээ-4</u>**<br>**TORCH халдвар** илрүүлэх оношилгоог нэвтрүүлнэ. | 25.0 | Шинжилгээ хийсэн үйлчлүүлэгчийн тоо | - | 50 | 150 | 180 | 200 | ЭЖТТ<br>ДТТ<br>АМБ<br>ЛАБ | Санхүүгийн алба |
| | **<u>Арга хэмжээ-5</u>**<br>Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээнд мөрдөх эмнэл зүйн удирдамж боловсруулан, батлуулж, мөрдөн ажиллана. | 0.6 | Боловсруулсан удирдамжийн тоо | 10 | 11 | 10 | 8 | 9 | ТТДТ<br>ЭЖТТ<br>ДТТ<br>АМБ<br>МЗМЭЭТ<br>НТ<br>ЭЭСТ | ЭМТҮЧАБА<br>Сувилахуйн алба<br>СЭШХХА |
| | | | Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо | - | 2 | 2 | 2 | 2 | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **_Зорилт 2._** Нярайн тусламж үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулж, сэргийлж болох эндэгдлийг бууруулах ажлыг зохион байгуулах | **Арга хэмжээ-1** Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих 10 алхам үйл ажиллагааг эрчимжүүлнэ. | 0.5 | Нярайг эхийн сүүгээр хооллох чиглэлийн сургалтын тоо | 5 | 7 | 8 | 10 | 12 | ТТДТ ЭЖТТ НТ ДТТ АМБ | Сувилахуйн алба СЭШХХА |
| | | | Эхийн сүүгээр хооллосон нярайн хувь | 90 | 92 | 93 | 95 | 96 | | |
| | **Арга хэмжээ-2** Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх | 1.9 | НЭҮНШТ-ын хувь | 75 | 80 | 90 | 95 | 98 | ТТДТ ЭЖТТ НТ | ЭМТҮЧАБА Сувилахуйн алба |
| | | 0.4 | НЭҮНШТ-ыг сургалтын тоо | 2 | 2 | 3 | 5 | 5 | | |
| | **Арга хэмжээ-3** Сэргийлж болох нярайн эндэгдлийг бууруулна. | 1.5 | 1000 амьд төрөлтөд нярайн эндэгдлийн түвшин (промиль) | 14.9 | 14.7 | 14.5 | 14.1 | 13.7 | ТТДТ ЭЖТТ НТ ДТТ АМБ | ЭМТҮЧАБА Сувилахуйн алба СЭШХХА |
| | **Арга хэмжээ-4** Нярайн скрининг оношилгоог тогтмолжуулна. | 300.0 | Нярайн сонсголын аппаратын тоо | 1 | 1 | 1 | - | - | НТ | Санхүүгийн алба |
| | | | Нярайн сонсгол шинжилсэн нярайн тоо | - | 1678 | 2500 | 3500 | 4800 | | |
| **_Зорилт 3._** Бичил биетний тэсвэржилтийн эсрэг үйд ажиллагааг хэрэгжүүлж, эмийн | **Арга хэмжээ -1** Бичил биетний тэсвэржилтийн эсрэг хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана. | 0.6 | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 88 | 90 | 92 | 92 | 94 | Эмийн эмчилгээг зохицуулах хороо | Эм зүйн алба Эмнэл зүйн тасгууд |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| аюулгүй байдлыг хангаж ажиллах | **<u>Арга хэмжээ-2</u>** Нянгийн тэсвэржилтийн хяналтын тогтолцоонд бэхжүүлж нянгийн эсрэг эмийн хэрэглээг бууруулж ажиллана. | 0.2 | Хяналт үнэлгээний тоо | 2 | 2 | 3 | 3 | 3 | Эмийн эмчилгээг зохицуулах хороо | Эм зүйн алба Эмнэл зүйнтасгууд |
| | | | Нянгийн эсрэг эмийн хэрэглээний хувь | 35 | 30 | 29 | 25 | 24 | | |
| ***Зорилт 4.*** Яаралтай тусламж, амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээний ур чадварыг сайжруулж, багаар тусламж үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллах | **<u>Арга хэмжээ-1</u>** Яаралтай тусламжийн үйлчилгээг шуурхай үзүүлэх үйл ажиллагаа зохион байгуулна. | 3.5 | Яаралтай тусламжийн дуудлагын дохиоллын системийн суурьлуулсан тасгийн тоо | 0 | 2 | 5 | 7 | 10 | МЗМЭЭТ ХАЯТТ | ЭМТҮЧАБА Сувилахуйн алба СЭШХХА |
| | | | Яаралтай тусламжаар сургасан багийн тоо | 1 | 2 | 2 | 2 | 3 | | |
| | | | Яаралтай тусламжийн сургалтын тоо | 2 | 3 | 5 | 5 | 6 | | |
| | **<u>Арга хэмжээ-2</u>** Амь тэнссэн үеийн тусламж, үйлчилгээний ур чадварыг сайжруулж ажиллана. | 2.5 | Амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээ үзүүлэх сургагч багшийн тоо | 0 | 1 | 2 | 2 | 2 | СЭШХХА | МЗМЭЭТ ХАЯТТ |
| | | | Ажлын байрны сургалтын тоо | 2 | 2 | 5 | 7 | 10 | | |
| | | 1.9 | Нийт эм, эмнэлгийн | 1 | 1.1 | 1.2 | 1.3 | 1.4 | АМБ | Эм зүйн алба |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ***Зорилт 5.*** Нөхөн үржихүйн эмэгтэйчүүдэд чиглэсэн гэр бүл төлөвлөлтийн боловсрол олгох, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж ажиллах | **Арга хэмжээ-1** Гэр бүл төлөвлөлтийн талаар мэдлэг олох, жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийг хүрэлцээг нэмэгдүүлнэ. | | хэрэгсэлд ЖСАХ ээлэх хувь | | | | | | | |
| | | | Гэр бүл төлөвлөлтийн зөвлөгөө өгсөн эмэгтэйчүүдийн тоо | 1404 | 1480 | 1520 | 1600 | 2000 | АМБ | НЭМДТ |
| | | | Гэр бүл төлөвлөлтийн талаар сургасан эмнэлгийн мэргэжилтний тоо | 11 | 2 | 2 | 3 | 4 | | |
| | **Арга хэмжээ-2** Гэр бүл төлөвлөлтийн тусламж үйлчилгээг өргөжүүлнэ. | 2.5 | ЖХАХ-ын сургалтын гарын авлагын тоо | 5 | 2 | 3 | 5 | 10 | АМБ | НЭМДТ |
| | | - | Давтан үр хөндөлтийн хувь | 0.5 | 0.3 | 0.3 | 0.2 | 0.2 | | |
| | | 4.0 | Үр хөндөлтийн өмнөх болон дараах өрөөний урсгалыг нэг чиглэлтэй болгосон байна. | - | - | 1 | 1 | - | | |
| | **Арга хэмжээ-3** Өсвөр үеийнхний дунд нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулна. | 0.6 | Сургалт хийсэн ЕБС-ын тоо | 2 | 2 | 3 | 3 | 5 | НЭМДТ АМБ | Сувилахуйн алба |
| | | 1.0 | Өсвөр үеийнхэнд чиглэсэн үйл ажиллагааны тоо | 3 | 4 | 4 | 5 | 5 | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Сургалтад хамрагдсан сурагчидын тоо | 153 | 180 | 200 | 210 | 300 | | |
| ***Зорилт 6.*** Халдварын сэргийлэлт хяналтын тогтолцоог бүрдүүлж, эмнэлгээс шалтгаалах халдварын тандалт судалгааг тогтмолжуулж, сэргийлэх үйл ажиллагаа нэмэгдүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах | **Арга хэмжээ-1** Эмнэлгийн гаралтай хог хаягдлын түр хадгалах байрыг зохих журмын дагуу их засвар хийж, үйл ажиллагаа зохион байгуулан ажиллана. | 3.0 | Түр хадлах байрын засвар хийсэн байна. | - | - | 1 | - | - | ХҮА | ХСХА |
| | **Арга хэмжээ-2** Ариутгалын тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулна. | 1.5 | Бохир багаж хэрэгслийг угаах бүрэн автомат угаалгын машинтай болно. | - | - | 1 | - | - | | |
| ***Зорилт 7.*** Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдлийн удирдлагы тогтолцоог бүрдүүлэх | **Арга хэмжээ-1** Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын 7 зорилтын хэрэгжилтийг хангаж ажиллана. | 3.0 | Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулахтай холбоотой тохиолдлын тоо | 9 | 9 | 8 | 7 | 6 | ЭМТҮЧАБА | НТ<br>ТТДТ<br>ЭЖТТ<br>ДТТ<br>АМБ<br>МЗМЭЭТ<br>ЭЭСТ |
| | | | Үр дүнтэй харилцаа үүсэх тохиолдлын тоо | 9 | 9 | 9 | 8 | 5 | ЭМТҮЧАБА Сувилахуйн алба | |
| | | | Эмийн аюулгүй байдлын тохиолдлын тоо | 7 | 7 | 6 | 5 | 5 | ЭМТҮЧАБА Эм зүйн алба | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Мэс заслын аюулгүй байдлын тохиолдлын тоо | 2 | 2 | 2 | 2 | 2 | ЭМТҮЧАБА ХСХА | |
| | | | Унах эрсдэлийн аюулгүй байдлын тохиолдлын тоо | - | - | - | - | - | ЭМТҮЧАБА Сувилахуйн алба | |
| | | | Эмнэлгээс шалтгаалах халдварын тохиолдлын хувь | 10 | 10 | 8 | 7 | 7 | ЭМТҮЧАБА ХСХА | |
| | | | Тээвэрлэлтийн аюулгүй байдлын тохиолдлын тоо | - | - | - | - | - | НТ ТТДТ ЭЖТТ ДТТ АМБ МЗМЭЭТ ЭЭСТ | |
| **СТРАТЕГИЙН ЗОРИЛГО-2: ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭР ТӨРӨЛ, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ.** | | | | | | | | | | |
| ***Зорилт-1.*** Үйлчлүүлэгчидэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх | **<u>Арга хэмжээ-1</u>** Тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг зохицуулсан журам боловсруулж, хэрэгжүүлж ажиллана. | 0.3 | Журмын хэрэгжилтийн хувь | 85 | 86 | 91 | 92 | 98 | ЭМТҮЧАБА | НТ ТТДТ ЭЖТТ ДТТ АМБ МЗМЭЭТ ЭЭСТ ХАЯТ |
| | | - | Байгууллагын веб сайтыг тогтмолжуулсан | 428 | 450 | 550 | 650 | 750 | НЭМДТ | НТ ТТДТ ЭЖТТ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **Арга хэмжээ-2** Байгууллагын үйл ажиллагааг нийтэд мэдээлэх тогтолцоог бүрдүүлж ажиллана. | | үйл ажиллагааны тоо | | | | | | | ДТТ АМБ МЗМЭЭТ ЭЭСТ ХАЯТ |
| | | | Цахим хуудасны дагагчийн тоо | 800.0 | 820.0 | 850.0 | 880.0 | 900.0 | | |
| | | | Цахим хуудсанд тавсан мэдээллийн тоо | 500 | 530 | 550 | 560 | 590 | | |
| ***Зорилт-2.*** Амбулатори, хүлээн авах, хэвтүүлэн эмчлэх тасгийн зохион байгуулалтыг үйл ажиллагаа, үйлчилгээний ачаалал, эрэлт хэрэгцээ, үйлчлүүлэгчийн урсгал, хөдөлгөөнтэй уялдуулан зохион байгуулах | **Арга хэмжээ -1** “Өдрийн эмчилгээ”-ны тусламж үйлчилгээг өргөжүүлнэ. | 0.6 | Өдрийн эмчилгээний үйлчлүүлэгчийн тоо | 337 | 0 | 250 | 350 | 400 | АМБ | НЭМДТ |
| | | | Өдрийн эмчилгээний үр дүнг тооцсон судалгааны тоо | 0 | 2 | 2 | 4 | 4 | | |
| | **Арга хэмжээ-2** Эмчилгээний хоолыг нэг хүний системд оруулж үйлчилж эхэлнэ. | 4.6 | Нэг хүний системээр хоол түгээсэн үйлчлүүлэгчийн тоо | - | 50 | 120 | 250 | 300 | НЭМДТ | ЭМДСМТА |
| | **Арга хэмжээ 3** Үйлчлүүлэгчийн хүлээгдэл, ачаалал, урсгал хөдөлгөөнд судалгаа хийж, үр дүнг тооцож ажиллана. | 0.2 | Үйлчлүүлэгчийн хүлээгдэл, ачаалалд хийсэн судалгааны тоо | - | 1 | 2 | 2 | 4 | НЭМДТ АМБ | ЭМДСМТА |
| | **Арга хэмжээ-1** Эмнэлгийн тусламж үйлчилгээнд бөөр орлуулах эмчилгээг нэвтрүүлнэ. | 123,0 | Гемодиализын эмчилгээний аппаратын тоо | - | 1 | - | - | - | МЗМЭЭТ | Санхүүгийн алба |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ***Зорилт-3.*** Эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг өргөжүүлэх | **Арга хэмжээ-2** MNS ISO 15189:2024 "Эрүүл мэндийн лаборатори -Чанар, чадавхид тавих шаардлага" Олон улсын стандарт нэвтрүүлнэ. | 11,7 | Боловсруулсан баримт бичгийн тоо | 3 | 10 | 5 | 5 | 5 | ЛАБ | ЭМТҮЧАБА Санхүүгийн алба |
| | | | Сургалтын тоо | - | 5 | 15 | - | - | | |
| | | | Батламжийн гэрчилгээ | - | - | 1 | - | - | | |
| | **Арга хэмжээ-3** MNS ISO 7101:2023 Эрүүл мэндийн байгууллагын чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэн ажиллана. | 25.0 | Үйл ажиллагааны тоо | - | 2 | 5 | 25 | 5 | ЭМТҮЧАБА | Бүх алба Бүх тасгууд |
| | | | Чанарын баталгаажилт батламж | - | - | - | 1 | - | | |
| | **Арга хэмжээ-4** Жирэмсний хяналтын тусламжийг нэвтрүүлнэ. | 1,5 | Жирэмсний хяналтад авсан жирэмсэн эмэгтэйчүүдийн тоо | - | 80 | 110 | 130 | 150 | АМБ | ТТДТ ЭЖТТ ДТТ |
| | **Арга хэмжээ-5** Ургийн гажгийг илрүүлэх хэт авиан тоног төхөөрөмжийн тоог нэмэгдүүлнэ. | 1.2 тэрбум | Нэмэгдүүлсэн хэт авиан шинжилгээний аппаратын тоо | 1 | 3 | - | - | - | Санхүүгийн алба | Удирдлагын баг |
| | | | Жирэмсний эрт илрүүлгийн тоо | 345 | 410 | 420 | 450 | 460 | АМБ | НЭМДТ |
| | **Арга хэмжээ-6** Эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслын хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 160.0 | Дурангийн иж бүрдлийн тоо | 6 | 1 | - | - | 1 | ЭЭСТ | Санхүүгийн |
| | | | Мэс засал эмчилгээ хийлгэсэн эмэгтэйчүүдийн тоо | 702 | 884 | 900 | 910 | 915 | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **Арга хэмжээ-7** Нийслэлийн эх, нярай, эмэгтэйчүүдийн төв болно. | 1,800.0 | Үйлчлүүлсэн эхийн тоо | - | - | 150 | 250 | 280 | Удирдлагын баг Санхүүгийн алба | ТТДТ ЭЖТТ ДТТ НТ |
| **СТРАТЕГИЙН ЗОРИЛГО-3: СУВИЛАХУЙ, ЭХ БАРИХУЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫГ САЙЖРУУЛЖ, ЖИГД ХҮРТЭЭМЖТЭЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ** | | | | | | | | | | |
| ***Зорилт-1*** Сувилахуй, эх барихуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлэх | **Арга хэмжээ-1** Сувилахуй, эх барихуйн тусламж, үйлчилгээний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлж ажиллана. | 2.0 | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | - | 85 | 87 | 90 | 95 | Сувилахуйн алба | НТ ТТДТ ЭЖТТ ДТТ АМБ МЗМЭЭТ ЭЭСТ ХАЯТ |
| | | | Тайлан танилцуулсан тоо | - | 1 | 2 | 2 | 4 | | |
| | **Арга хэмжээ-2** Сувилахуй, эх барихуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийг боловсруулж, дүн шинжилгээ хийж ажиллана. | - | Шалгуур үзүүлэлтийн биелэлтийн хувь | 80 | 85 | 88 | 90 | 92 | | |
| | **Арга хэмжээ-3** Сувилахуй, эх барихуйн тусламж, үйлчилгээний эрсдлийн үнэлгээ хийж ажиллана. | 1.1 | Эрсдлийн үнэлгээ хийсэн тоо | - | 1 | 2 | 2 | 2 | | |
| | | | Сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | 85 | 90 | 90 | 95 | | |
| | **Арга хэмжээ-4** Эх баригч нарын бие даасан тусламж үйлчилгээ үзүүлэх, | - | Хэвийн төрөлт удирдсан эх баригчийн тоо | - | 3 | 3 | 3 | 5 | ТТДТ | ЭЖТТ АМБ ДТТ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэвийн төрөлтийг удирдуулах чадварт сургана. | | Эх баригчаар удирдуулсан төрөлтийн тоо | - | 8 | 10 | 25 | 35 | | |
| | **<u>Арга хэмжээ-5</u>** Эмнэл зүйн сургагч багшийн тоог нэмэгдүүлнэ. | 1.0 | Сургагч багшийн тоо | 1 | 2 | 5 | 3 | 2 | СЭШХАА | Сувилахуйн алба |
| | | | Сургалтын тоо | 1 | 2 | 2 | 2 | 2 | | |
| | **<u>Арга хэмжээ-6</u>** Сувилахуй, эх барихуй, нөхөн үржихүйн чиглэлээр бусад эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллана. | 0.5 | Нөхөн үржихүйн сургалтад хамрагдсан өрхийн эмчийн тоо | - | 30 | 50 | 55 | 60 | АМБ | СЭШХАА |
| | | | Сургалтын тоо | - | 1 | 2 | 2 | 3 | | |
| ***Зорилт-2*** Сувилагч, эх баригч нарын хөдөлмөрийн аюулгүй байдал хангаж, ажлын байрны эрсдэлээс хамгаалж ажиллах | **<u>Арга хэмжээ-1</u>** Сувилагч, эх баригчийн хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй байдалд үнэлгээ хийж, үйл ажиллагаа хэрэгжүүлж ажиллана. | 2.5 | Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийсэн ажлын байр | - | 1 | 2 | 2 | 2 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан | Санхүүгийн алба ХҮА |
| | **<u>Арга хэмжээ-2</u>** Ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлж ажиллана. | 1.5 | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | - | 75 | 80 | 90 | 95 | Захиргаа, хүний нөөцийн хөгжлийн алба | Санхүүгийн алба ХҮА |
| **СТРАТЕГИЙН ЗОРИЛГО-4: НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАНА.** | | | | | | | | | | |
| | **<u>Арга хэмжээ-1</u>** Эрүүл мэндийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/241 тоот тушаалыг хэрэгжүүлэх, ДЭМБ-ын 2030 | 1.5 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | 90 | 92 | 92 | 95 | | |
| | | | Умайн хүзүүний хавдар илрүүлэх | 1252 | 1260 | 1300 | 1310 | 1350 | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | он хүртлэх 90/70/90 хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана. | | шинжилгээний тоо | | | | | | ЭЭСТ АМБ | НЭМДТ |
| | | | Эмчилгээнд хамруулсан үйлчлүүлэгчийн | - | - | 35 | 40 | 40 | | |
| | | | Умайн хүзүүний хавдар, хавдрын урьдал илэрсэн эмэгтэйчүүдийн тоо | 40/3 | 49/3 | - | - | - | | |
| | | | Хөхний үзлэгийн тоо | 479 | 480 | 495 | 502 | 505 | | |
| | | | Мэдээлэл сурталчилгааны тоо | - | 80 | 120 | 150 | 160 | | |
| | **Арга хэмжээ-2**<br>"Хүн төв"-тэй Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ<br>"Эрүүл амьдралыг иргэн бүрт төлөвшүүлэх" зорилтын хүрээнд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулна. | 0,5 | Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан үйлчлүүлэгчдийн тоо | 630 | 650 | 700 | 780 | 850 | | |
| | | | Үйл ажиллагааны тоо | 0 | 2 | 2 | 2 | 2 | | |
| ***Зорилт 1***<br>Халдварт бус эмгэгийн эрсдэлт хүчин зүйлийг тандах, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эмчлэх, хяналтын тогтолцоог сайжруулах | **Арга хэмжээ-3**<br>Нийгмийн Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг үе шаттайгаар өргөжүүлнэ. | 1.3 | Сургалтад хамрагдах өсвөр насны хүүхдүүдийн тоо | 458 | 638 | 650 | 700 | 750 | НЭМДТ АМБ | НТ<br>ТТДТ<br>ЭЖТТ<br>ДТТ<br>АМБ<br>МЗМЭЭТ<br>ЭЭСТ |
| | | | Нэмэгдүүлсэн мэргэжлийн эмчийн тоо | 2 | 2 | 3 | 3 | 3 | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн үйлчлүүлэгчийн тоо | 150 | 153 | 170 | 180 | 190 | | ХАЯТ |
| | | | Эрүүл мэндийн дэлхийн өдөр тэмдэглэсэн үйл ажиллагааны тоо | 2 | 3 | 3 | 3 | 4 | | |
| | **Арга хэмжээ-4**<br>Өсвөр насны охид, хөвгүүдэд "Нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн боловсрол олгох" сургалт зохион байгуулана. | 0.5 | Сургалтын тоо | 5 | 5 | 12 | 15 | 15 | НЭМДТ | АМБ |
| | | | Сургалтад хамрагдсан охид хөвгүүдийн тоо | 85 | 90 | 150 | 250 | 300 | | |
| | **Арга хэмжээ-5**<br>"Эерэг харилцааг дэмжье" арга хэмжээг зохион байгуулна. ("Стресс менежмент", "Ажлаас халшрах хам шинж") | 0.6 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2 | 1 | 1 | 1 | 1 | НЭМДТ | АМБ |
| | | | Эмч, ажилтнуудын тоо | 205 | 220 | 230 | 250 | 300 | | |
| | **Арга хэмжээ-6**<br>Эрүүл ажлын байр-Идэвхтэй хөдөлгөөн уриан дор биеийн тамир үйл ажиллагааг идэвхжүүлнэ. (иог, бужиг) | 1.0 | Үйл ажиллагааны тоо | 1 | 2 | 2 | 2 | 2 | | |
| ***Зорилт-2***<br>Халдварт өвчнөөс урьдчилан | **Арга хэмжээ-1**<br>БЗДХ өвчний эрт илрүүлэлт, тандалт, судалгаа хийж, эрт | 1.4 | БЗДХ-ын илрүүлэг үзлэгийн тоо | 7150 | 7200 | 7500 | 8100 | 8300 | АМБ | НЭМДТ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| сэргийлэх, хянах, илрүүлэх тандалт, хариу арга хэмжээ авч ажиллах | илрүүлэг хийх, эмчлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллана. | | Эдгэрсэн үйлчлүүлэгчийн тоо | 350 | 451 | - | - | - | | |
| | | | БЗДХ-ын сургалт, сурталчилгааны тоо | 126 | 135 | 159 | 180 | 255 | | |
| | **Арга хэмжээ-2**<br>Товлолт дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлж ажиллана. | - | Товлолт дархлаажуулалтын хамрагдалтын хувь | 93.5 | 93.5 | 93.8 | 94.3 | 94.8 | НТ<br>ХСХА | Сувилахуйн алба |
| | **Арга хэмжээ-3**<br>Ажилтнуудын томуугийн дархлаажуулалтад хамруулж, халдварт өвчнөөс сэргийлж ажиллана. | 2.8 | Дархлаажуулалтад хамрагдсан ажилтнуудын тоо | 200 | 230 | 200 | 220 | 240 | ХСХА | Сувилахуйн алба |
| **СТРАТЕГИЙН ЗОРИЛГО-5: ЭМНЭЛГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЖ, ШИНЖЛЭХ УХААНЫ НОТОЛГООНД СУУРИЛСАН АНАГААХ УХААНЫ ХӨГЖҮҮЛЭН, ШИНЭ ИННОВАЦИ ХӨГЖҮҮЛНЭ.** | | | | | | | | | | |
| ***Зорилт-1***<br>Эх, нярай эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээнд нотолгоонд суурилсан анагаах ухааныг хөгжүүлж, олон улсын анагаах ухааны хөгжилтэй | **Арга хэмжээ -1**<br>"Орчин үеийн эмчилгээ оношилгооны асуудал" сэдэвт Олон Улсын хурлыг эх барих эмэгтэйчүүд, нярай, мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний чиглэлээр зохион байгуулна. | 15,0 | Илтгэлийн тоо | 10 | 10 | 5 | 3 | 7 | НТ<br>ТТДТ<br>ЭЖТТ<br>ДТТ<br>АМБ<br>МЗМЭЭТ<br>ЭЭСТ<br>ХАЯТ | СЭШХАА<br>Сувилахуйн алба |
| | | | Хуралд оролцсон эмч, мэргэжилтнүүдийн тоо | 50 | 80 | 100 | 120 | 120 | | |
| | **Арга хэмжээ-2** | 3,0 | Сургалтад хамрагдсан | 34 | 40 | 45 | 50 | 55 | СЭШХАА | НТ<br>ТТДТ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| мөр зэрэгцэн ажиллах | Олон Улсын туршлага судлах богино хугацааны сургалтад хамруулна. | | эмч,ажилтнуудын тоо | | | | | | Сувилахуйн алба | ЭЖТТ ДТТ АМБ МЗМЭЭТ ЭЭСТ ХАЯТ |
| | | | Олон Улсын сургалтын тоо | 4 | 3 | 2 | 2 | 5 | | |
| | **<u>Арга хэмжээ-3</u>** Эх баригчдын ур чадварыг харьцуулсан нь" Олон улсын судалгаа хийж, үр дүнг тооцно. | 1,0 | Судалгааны гүйцэтгэлийн хувь | 75 | 80 | 90 | 92 | 92 | | ЭЖТТ БНТУ-ын ЭГЭ их сургууль |
| | | | Онлайн бага хурлын тоо | 0 | 1 | 1 | 1 | 1 | | |
| ***Зорилт-2*** Эмнэлгийн тусламж үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технолсги, инновацийг нэвтрүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлж ажиллах ажиллах | **<u>Арга хэмжээ-1</u>** "Захын хураагуур судсанд уртасгагчтай уян зүү тавих" технологийг эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлнэ. | 1,0 | Уян зүү хэрэглэсэн нярайн тоо | 0 | 50 | 70 | 80 | 120 | НТ | Сувилахуйн алба |
| | **<u>Арга хэмжээ-2</u>** SINGLE PORT-ыг эмэгтэйчүүдийн дурангийн мэс засалд нэвтрүүлэн ажиллана. | 2,0 | Single port хэрэглэсэн эмэгтэйчүүдийн тоо | - | 10 | 20 | 50 | 55 | ЭЭСТ | СЭШХАА ЭМТҮЧАБА |
| | **<u>Арга хэмжээ-3</u>** VNOTES мэс заслыг эмэгтэйчүүдийн дурангийн мэс засалд нэвтрүүлэн ажиллана. | 3,0 | Үйлчлүүлсэн хүний тоо | - | 2 | 10 | 15 | 20 | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **Арга хэмжээ-4**<br>Зуршмал зулбалттай эмэгтэйчүүдэд цусны сийвэнд прогестрон дааврыг тодорхойлох оношилгоог нэвтрүүлнэ. | 4,0 | Хийсэн шинжилгээний тоо | - | 80 | 90 | 100 | 105 | ДТТ | ЭЖТТ |
| | **Арга хэмжээ-5**<br>"Clean Bench" тариа найруулгын вакум шүүгээ тусламж үйлчилгээнд нэвтрүүлнэ. | 40,0 | Шүүгээний тоо | - | 1 | - | - | - | НТ | Санхүүгийн алба |
| | **Арга хэмжээ-6**<br>Төрөлтийн үеийн нугасны гадна хөндийн өөрөө удирдлагт үргэлжилсэн өвдөлт намдаалтыг нэвтрүүлнэ. | 30,0 | Өвдөлт намдаалт хийсэн үйлчлүүлэгчийн тоо | 0 | 30 | 50 | 100 | 150 | МЗМЭЭТ | ТТДТ |
| **СТРАТЕГИЙН ЗОРИЛГО-6: УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО БОЛОВСРУУЛЖ ХЭРЭГЖҮҮЛНЭ.** | | | | | | | | | | |
| ***Зорилт 1.***<br>Үйлчлүүлэгч, ажилтнуудад ээлтэй орчин бүрдүүлж, тохижилтийг үе шаттай зохион байгуулан ажиллах | **Арга хэмжээ-1**<br>Эмнэлгийн эмийн санг стандартын дагуу зохион байгуулж, эмийн нөөцийн өрөөг төрөлжүүлэн тохижуулах байх | - | Эмийн сангийн тохижилт хийсэн өрөөний тоо | 0 | 1 | 2 | 2 | 2 | Эм зүйн алба | ХҮА<br>Санхүүгийн алба |
| | **Арга хэмжээ-2**<br>эмчилгээний хоолны шинэ цэсийг өвчний нэршлээр боловсруулж, баталсан аргачлалын дагуу хоол үйлдвэрлэлийг хийнэ. | - | Шинээр боловсруулсан эмчилгээний хоолны технологи картын тоо | 40 | 48 | 10 | 10 | 12 | Хоол үйлдвэрлэлийн хэсэг | НЭМДТ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **Арга хэмжээ-3**<br>Төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагаанд **Dashboard систем** нэвтрүүлнэ. | 12.0 | Цахим хөгжүүлэлтийн бэлэн байдал хангасан үйл ажиллагааны тоо | - | 2 | 2 | 3 | 5 | СЭШХАА | Санхүүгийн алба<br>Захиргаа, хүний нөөцийн хөгжлийн алба<br>ЭМДСМТА |
| | | | **Dashboard** систем ашиглах сургалтын тоо | - | - | 4 | 4 | 4 | | |
| ***Зорилт 2.***<br>Хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, сургах, чадавхжуулах, урамшуулах арга хэмжээг хэрэгжүүлэх | **Арга хэмжээ-1**<br>2026-2029 оны Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжүүлнэ. | 3.8 | Батлагдсан хөтөлбөр | 0 | 1 | - | - | - | Захиргаа, хүний нөөцийн алба | СЭШХАА<br>ЭМТҮЧАБА<br>Сувилахуйн алба |
| | | | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | - | 10 | 80 | 90 | 95 | | |
| | **Арга хэмжээ-2**<br>Эмч, эмнэлгийн мэргэжилтний тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг хангаж ажиллана. | - | Урамшуулал олгосон ажилчдын тоо | 250 | 260 | 290 | 300 | 350 | Захиргаа, хүний нөөцийн алба | Санхүүгийн алба |
| | | 2.5 | Ажилтнуудад чиглэсэн үйл ажиллагааны тоо | 10 | 11 | 12 | 15 | 15 | | |
| | | 1.5 | Эмч, ажилтнуудыг биеийн тамир, спортын дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэх боломжийг бүрдүүлсэн үйл ажиллагааны тоо | 1 | 2 | 2 | 3 | 4 | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 0.8 | Гадаад улсад урт хугацааны сургалтад хамруулсан ажилтнуудын тоо | 34 | 49 | 41 | 38 | 45 | СЭШХАА | Захиргаа, хүний нөөцийн алба |
| **СТРАТЕГИЙН ЗОРИЛГО – 7: ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН ТОГТОЛЦООНЫ ТЕХНИК ТЕХНОЛОГИЙГ САЙЖРУУЛАХ, ДЭЛХИЙН ЖИШГИЙН ЦАХИМ ЭМНЭЛГИЙГ ҮЕ ШАТТАЙ ТӨЛӨВШҮҮЛЭН ЗОХИОН БАЙГУУЛНА.** | | | | | | | | | | |
| ***Зорилт-1.*** Мэдээллийн удирдлага, мэргэжил арга зүйгээр хангах чиглэлээр эмнэлгийн тусламж үйлчилгээг цахимжуулж, хялбаржуулах үйл ажиллагаар зохион байгуулан ажиллана. | **Арга хэмжээ-1** Мэдээллийн удирдлагыг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлж ажиллана. | 4.8 | Хөтөлберийн биелэлтийн хувь | 58 | 85 | 90 | 95 | 95 | ЭМДСМТА | ХҮА |
| | **Арга хэмжээ-2** Төрөх өрөө, мэс заслын өрөөний хяналтын камерын тоог нэмэгдүүлж, хяналтын системийг өргөжүүлж ажиллна. | 60.00 | Нэмэгдүүлсэн камерын тоо | 125 | 131 | 135 | 140 | 155 | ЭМДСМТА | ХҮА |
| | ***Арга хэмжээ-3*** Мэдээллийн тоног төхөөремжийн шинэчлэлт хийж ажиллана. | 3.0 | Тасаг, албадуудын дотсод холбооны ашиглалтын хувь | - | 20 | 50 | 90 | 100 | ЭМДСМТА | Албад Тасгууд |

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

С.МӨНХЗУЛ /ЭМЧИЛГЭЭ ЭРХЭЛСЭН ОРЛОГЧ ДАРГА, Ph.D, ТЭРГҮҮЛЭХ ЗЭРГИЙН ЭМЧ/

М.ЭНХДАЛАЙ /ЭМТҮЧАБА-ны ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ ЗЭРГИЙН ЭМЧ/